



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 23 өдөр

Дугаар А/433

Мандалговь

Газар эзэмших эрхийн гэрчилгээг
хүчингүй болгох тухай

Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.5, 40.1.6 дахь заалт, Барилгын тухай хуулийн 26 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сайнцагаан сумын 7 дугаар багийн нутаг дэвсгэр Төв халхын дуулалт, жүжгийн театрын баруун талд байршилтай “Даадаа групп” ХХК (РД:6275869)-ний орон сууцны зориулалттай 900м.кв (0,09га) газрын эрхийн гэрчилгээ эзэмшигч газрын төлбөрөө хугацаанд нь төлөөгүй, мөн хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээнд заасан зориулалтын дагуу тухайн газраа 2 жил дараалан ашиглаагүй, 2018 оны 05 дугаар сард барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөлгүй барилгын суурийн нүх ухаж, өнөөдрийг хүртэл иргэдийн ая тухтай, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг ноцтой зөрчиж байгаа тул газар эзэмших эрхийг хүчингүй болгосугай.

2. Дээрх аж ахуй нэгжийн газар эзэмших гэрээг цуцалж, гэрчилгээг хүчингүй болгохыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт үүрэг болгосугай.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулж аймгийн Засаг даргын 2019 оны А/272 дугаар захирамжийн “Даадаа групп”ХХК-д холбогдох хэсэг мөн газар эзэмших 000005042 тоот гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

431210633